

## Солонгост оршин суугаа гадаад иргэдэд(18-с дээш нас) Корона19 халдварын эсрэг вакцины 3 дахь тунг (нэмэлт) хийх заавар

Вакцинд хамрагдсанаас хойш хугацаа өнгөрөх тусам үр дүн буурч халдвар авах эрсдэл өсдөг байна. Корона 19-н эсрэг вакцины 3 дахь тунг/нэмэлт/хийлгэх нь үндсэн вакцинжуулалтаас илүү халдварлалт болон хүндрэлээс сэргийлэх үр дүнтэй гэдэг нь нотлогдоод байна.

Сүүлийн үед халдвар авагчдын дотор гадаад иргэдийн тоо нэмэгдэж байгаатай харьцуулахад 3дахь /нэмэлт/ вакцинд хамрагдагсдын хэмжээ бага байгаа тул Солонгосын нийгэмд аюулгүй амьдрахын тулд 3 дахь тунгаа заавал хийлгэхийг хүсэж байна.

**Дотоодод болоод гадаадад үндсэн вакцинаа хийлгэсэн 18-с дээш насны гадаад иргэдэд 3дахь тунг/нэмэлт/ үнэ төлбөргүй хийнэ.**

### ○ Вакцинжуулалтын хугацаа

- Үндсэн вакцинжуулалт хийгдсэнээс хойш 3сар(90хоног)өнгөрвөл 3дахь тунг/нэмэлт/ хийлгэх боломжтой. Janssen вакцин хийлгэсэн хүн 2дахь тунг/нэмэлт/ хийлгэнэ.

\* Үндсэн вакцинжуулалт : Pfizer·Moderna·Astrazeneca вакцин 2удаа, Janssen 1удаа.

- Үндсэн вакцинжуулалт хийгдсэнээс хойш 6 сарын дотор 3дахь тунд хамрагдаагүй бол халдварт өвчнөөс сэргийлэх нэвтрүүлэх бичиг хүчингүй болох бөгөөд, 3дахь тунд хамрагдсан даруйд дахин сэргээгдэх болно.

### ○ Вакцины төрөл ба вакцинжуулалт хийгдэх газар

- 3 дахь тунг нь mRNAвакцин (Pfizer·Moderna)-р хийгдэж байна. Janssen вакцинд хамрагдагч нь 2 дахь тунгаа/нэмэлт/ Janssen вакцин хийлгэхийг хүсвэл эрүүл мэндийн газраас лавлана уу.

- Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан эсэхээс шалтгаалахгүй Корона 19-н вакцинжуулалт хийж байгаа эмнэлгийн газар болон эрүүл мэндийн газарт хийлгэх боломжтой.

### ○ Урьдчилсан захиалга хийх арга

#### ① Дотоодод үндсэн вакцинд хамрагдагч гадаад иргэн

**1) Гадаадын иргэний бүртгэлтэй гадаад иргэд :** Үндсэн вакцинжуулалт хийлгэсэнтэй нэгэн адилаар онлайн болон утсаар урьдчилан захиалга өгөх боломжтой.

\* онлайн аар захиалга өгөх: Корона19 вирусг эсрэг вакцины урьдчилсан захиалгын систем (<https://ncvr.kdca.go.kr>) руу нэвтрэн орж өөрийгөө баталгаажуулан захиалах

\*\* утсаар захиалга өгөх: Халдварт өвчин хянах урьдчилан сэргийлэх газрын лавлах утас (☎1339) болон орон нутгийн засаг захиргаа тус бүрийн захиалга зөвлөгөө авах утас (<https://ncv.kdca.go.kr> нэвтрэх →‘Корона19 вакцины утсаар захиалга хийх байгууллагын байдал’ хэсгээс шалгах)

**2) Гадаадын иргэний бүртгэлгүй иргэд(Хууль бусаар оршин суугаа иргэд) :** Үндсэн вакцинжуулалт хийлгэхдээ эрүүл мэндийн газраас авсан түр хяналтын дугаараа хэрэглэн утсаар болоод тарилга хийгдэж байгаа газар(эмнэлэг, эрүүл мэндийн газар) биечлэн очиж захиалга өгөх.

#### ② Гадаадад үндсэн вакцинаа хийлгэсэн иргэд(90-с доош богино хугацаагаар оршин суугаа гадаад иргэд)

- Паспорттайгаа ойрхон байгаа эрүүл мэндийн төв дээр очих, түр хяналтын дугаар аван гадаадад вакцин тариулснаа бүртгүүлсний дараа утсаар болоод тарилга хийгдэж байгаа газар(эмнэлэг, эрүүл мэндийн газар) биечлэн очиж захиалга өгөх.

\* Гадаадын иргэний бүртгэлтэй гадаад иргэн нь түр хяналтын дугаар авах шаардлагагүй.

※ Тайлбар

- Хувь хүний мэдээллийг зөвхөн вакцинжуулалтын зорилгоор ашиглах бөгөөд мэдээлэх үүргээс чөлөөлөх журмын дагуу Цагаачлалын албанд хууль бусаар оршин суугч болохыг мэдээлэхгүй болно.
- Бусад тодорхой мэдээллийг Халдварт өвчин хянах урьдчилан сэргийлэх газар Корона19 вакцинжуулалт Нүричиб (<https://ncv.kdca.go.kr>)-с шалгана уу.



Эмэгтэйчүүд гэр бүлийн яам



Халдварт өвчин хянах урьдчилан сэргийлэх газар

<Энэхүү орчуулгыг Данүри төв 1577-1366 хийв>